

## АЗИЙН ВИДЕО САЛБАРЫН ХОЛБОО (AVIA) - 2024 ОНЫ ТАЙЛАНГААС

Азийн видео салбарын холбоо (AVIA) нь Сингапур улсад төвтэй, Азийн олон сувгийн телевизийн өргөн нэвтрүүлгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн холбоо юм. Тус холбоо өмнө нь Азийн кабелийн болон хиймэл дагуулын өргөн нэвтрүүлгийн холбоо (CASBAA) нэрээр олонд танигдсан бөгөөд анх 1991 онд үүсгэн байгуулагджээ. AVIA нь өнөөдөр тоон олон сувгийн телевиз, контент, дамжуулалтын платформууд, зар сурталчилгаа, видео контентын түгээгч зэрэг видео контентын салбарын олон талын үйлчилгээ эрхлэгчдийг нэгтгэсэн томоохон байгууллага болж өргөжөөд байна.



AVIA нь 130 гаруй гишүүн байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн бөгөөд Ази болон дэлхийн бусад орны кабель, хиймэл дагуул, DTH, өргөн зурвасын операторууд, үндэстэн дамнасан сүлжээ, телевизийн контент үйлдвэрлэгчид багтдаг. Мөн AVIA-ийн гишүүн байгууллагуудад өргөн нэвтрүүлгийн технологийн чиглэлээр тэргүүлэгч ханган нийлүүлэгчид, үйлдвэрлэгчид, харилцаа холбоо, зар сурталчилгаа, маркетингийн агентлагууд, хэвлэл мэдээлэл, засгийн газрын зохицуулах байгууллагууд, харилцаа холбооны оператор компаниуд, шинээр үүсэж буй медиа үйлчилгээ үзүүлэгчид зэрэг олон төрлийн бизнесийн төлөөлөл багтдаг байна.

Азийн видео салбарын холбоо нь Ази Номхон далайн орнуудын видео салбар, экосистемийг бүхэлд нь хамрах худалдааны холбоо гэж өөрсдийгөө тодорхойлсон бөгөөд гишүүдийнхээ нийтлэг ашиг сонирхлыг дэмжих замаар салбараа илүү хүчирхэг, эрүүл болгохын төлөө ажилладаг байна. Медиа салбарын дэлхийн чиг хандлагыг тодорхойлж, Азийн видео зах зээлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаардаг байгууллага юм.

Азийн Видео Салбарын Холбооноос жил бүр Видео салбарын бүхий л асуудлаар төрөл бүрийн (*OTT Summit, Asia Media Summit, Asia Video Summit, Satellite Industry Forum, Policy Roundtable* зм) бага хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн зохион байгуулахаас гадна видео салбарт гарч байгаа сүүлийн үеийн технологи, шинэ тутам нэвтэрч байгаа үйлчилгээ, тулгарч буй бэрхшээл, асуудлын талаар төрөл бүрийн судалгаа, тайлан, нийтлэл гаргадаг байна. Иймд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид тус холбооны албан ёсны цахим хуудсанд <https://avia.org/> зочилж, сүүлийн үеийн судалгаа, тайлан, мэдээлэлтэй танилцах боломжтой.

Энэ удаа та бүхэнд тус Холбооноос 2024 онд гаргасан “Азийн Видео Салбарын Тайлан 2024” тайлангийн Технологи гэсэн бүлгээс “Яагаад хэвлэл мэдээллийн дараагийн үе үүлэн технологийг шаардаж байна вэ”(Why the Next Generation of Media requires a new approach to Cloud), “Мэдээллийн хэрэгслийн хувьсан өөрчлөгдөж буй орчин: Үзэгчдийн дадал зуршлаас үүдэн шинж технологи үүсч гарах нь” “Evolving media landscape: from viewing habits to new technologies” гэсэн нийтлэлүүдийг орчуулан, зарим хэсэгт нэмэлт тайлбартайгаар хүргэж байна.

<https://avia.org/>

## ЯАГААД МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН (МЕДИА) ДАРААГИЙН ҮЕ ҮҮЛЭН ТЕХНОЛОГИЙГ ШААРДАЖ БАЙНА ВЭ?

Why the Next Generation of Media requires a new approach to Cloud

Ази Номхон далайн бүс нутагт стриминг болон онлайн видео контентын салбар бүрэн өөрчлөгдөж шинэ шинэ хандлага, боломжуудыг нээж байна. Өргөн нэвтрүүлгийн дамжуулалтын загвар нь нэг цэгээс олон цэгт нэгэн зэрэг мэдээллийг хүргэдэг нэг чиглэлтэй байсан бол одоо медиа компаниуд хэрэглэгчдэд зориулсан хоёр талын хандалт бүхий шийдлүүдийг санал болгож, хувь хүнд зориулсан тохиргоо хийх, тохирсон контентыг нь хүргэхэд илүү анхаарч байна. Хэрэглэгч хэзээ ч хандах боломжтой, үргэлж нээлттэй ажиллах зарчимд суурилсан үйлчилгээ нь үзэгчдийн хүлээлтэд нийцсэн, интерактив контентыг бий болгох шинэ хандлага руу шилжээд байна. Медиа компаниуд хэрэглэгчдэдээ шинэ, шинэлэг үйлчилгээнүүдийг үзүүлэх боломж улам бүр нэмэгдэж байна.



Ийнхүү өөрчлөлт хийх боломж нэмэгдэж байгаа нь шинэ тутам гарч буй технологийн шинэчлэлүүдээс үүдэлтэй бөгөөд энэ нь медиа салбарт илүү уян хатан, хэрэглэгчийн шаардлагад нийцсэн шийдлүүдийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэж байна. Хиймэл оюун ухаан, машин сургалтын технологи, автоматжуулсан контент бүтээх арга техникүүд нь “storytelling personalization” буюу тухайн хэрэглэгчдийн талаарх өгөгдөл буюу хувь хүний сонголт, сонирхол, зан төлөв дээр үндэслэн контентоо илүү тохирсон байдлаар хүргэх боломжуудыг улам бүр өргөжүүлж байна. Гэсэн хэдий ч бодит цаг хугацаанд нь (real time) тоглох тоглоом, өндөр нарийвчлалтай дүрсийн шууд дамжуулалт, AR, VR зэрэг дараа үеийн контентын үйлчилгээнүүдийг хэрэглэгчдэд саадгүй дамжуулах ёстой учир суурь дэд бүтцэд шинэ шинэ шаардлагууд тавигдаж байна.

Үзэгчдэд хүссэн үедээ, дэлхийн хаана ч байсан оновчтой контент үзүүлэх боломж олгохын тулд интернэтийн гол зангилаа цэгээс эхлээд хэрэглэгч хүртэлх үүлэн тооцоололд цоо шинэ арга барил шаардлагатай бөгөөд энэ нь хөгжүүлэгчид болон компаниудын контент бүтээх, байршуулалт хийх, тооцооллын бүхэл бүтэн ажлын үе шатууд дахь өгөгдлийн аюулгүй байдлыг хангах зэрэг уламжлалт арга замаа өөрчлөх шаардлагатай байна. Дэлхий даяарх олон тэрбум интернэт хэрэглэгчид дижитал хэрэглээний талаар илүү туршлагатай болсноор тэдэнд дараа үеийн контентын төрөл бүрийн програмуудыг хялбархан хүргэх боломжийг нээж өгч байна.

## Медиа салбарын дараа үеийн үндсэн хэрэгцээ

Хэрэглэгчдийн хүлээж буй хэрэгцээг хангахын тулд медиа компаниуд стратеги зорилгоо үүнд тохируулан өөрчлөх ёстой. Тэдэнд асар их хэмжээний видео файлуудыг хадгалах, боловсруулах платформтой байх шаардлага тулгарч байгаа бөгөөд, үүний зэрэгцээ үзэгчдийн эрэлтийн өсөлтийг хангахын тулд цар хүрээгээ нэмэгдүүлэх чадвартай байх хэрэгтэй. Иймд, медиа компаниуд ил тод үнийн системтэй, илүү хямд зардал бүхий үүлэн хөрөнгө оруулалтаас оновчтой өгөөж авах чадвартай байхыг шаарддаг. Энэ нь контентыг хямд, найдвартай байдлаар дамжуулах, хэрэглэгчдийн хэрэгцээг хурдан шуурхай хангах боломжийг олгож, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Онлайн дамжуулалт нь бидний өдөр тутмын амьдралд аль хэдийн гүнзгий нэвтэрсэн хэдий ч, хэрэглэгчдийн урьд өмнө хараагүй шинэ технологид суурилсан үйлчилгээ гарч, техник технологийн өвөрмөц сорилтуудыг даван туулах шаардлага урган гарсаар байна. Видеог дамжуулахад их хэмжээний өгөгдөл дамжуулдгийн улмаас хэрэглэгчдэд файл таталт (буфер) хийх үед гацалт, хоцрогдол үүсэх зэрэг техникийн асуудал болон хэрэглэгчийн туршлага, зан төлөвтэй холбоотой төвөгтэй бэрхшээлүүд, бодит эрсдэлүүд үргэлж гарч байдаг.

Нэмж дурдахад, шууд дамжуулалт нь контент түгээгчид болон бусад байгууллагуудад (жишээ нь зар сурталчилгаа түгээж байгаа бизнесийн байгууллага, хувь хүн гм) үзэгчдийг өдөөж, бодит цаг хугацаанд (live) үзэгчидтэй холбогдох маш сайн арга хэрэгсэл юм. Энэ нь контентын интерактив байдлыг нэмэгдүүлж, үзэгчдийн оролцоог хангах боломжийг олгодог.

Гэсэн хэдий ч өнөөгийн онлайн медиа орчинд өрсөлдөж буй олон төрлийн платформууд, сүлжээний хандалтууд, дамжуулах форматуудын олон янз байдлаас шалтгаалан шууд дамжуулалтыг хүргэхэд хүндрэлүүд гарч байна. Жишээлбэл, үзэгчдийн хандалт серверийн багтаамжаас давсан тохиолдолд хэрэглэгчид тухайн шууд дамжуулалтыг орхих магадлалтай байдаг. Үүнээс гадна сүлжээний ачаалал, хоцрогдол, багц дахь алдагдлын (packet loss) улмаас видео контентын гүйцэтгэл муудаж ингэснээр үзэгчдийн сэтгэл ханамжид сөрөг нөлөө үзүүлж, өөр илүү сайн чанартай видео эрэлхийлэхэд хүргэдэг бөгөөд медиа компаниудын хувьд чанартай үйлчилгээг санал болгох, серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, контентыг найдвартай, тогтвортой дамжуулахад анхаарах шаардлагатай болдог.

Контентыг хүлээн авч үзэж сурсан, туршлагатай хэрэглэгчдэд **ҮҮЛЭН ТООЦООЛЛЫГ АЛЬ БОЛОХ ОЙРТУУЛАХ** нь эдгээр эрсдэлийг бууруулдаг. Энэ нь хамгийн өндөр нарийвчлалтай видео хэрэглэгчдэд хамгийн сайн үзүүлэлтээр хангахын зэрэгцээ медиа үйлчилгээ үзүүлэгчдэд сүлжээний ачаалал, саатлын асуудлыг үр дүнтэй удирдах боломжийг олгодог.

## [Дараа үеийн үүлэн технологийн үйлчилгээний сонголтын талаар](#)

Дараа үеийн OTT үйлчилгээ нь нарийн төвөгтэй программ хангамжууд, ачаалал ихтэй ажлын горимтой байдаг учир үүнийг хэрэглэгчдэд ойр байдлаар шийдвэрлэх тусам дамжуулалт чанартай болох юм. Тухайлбал “Akamai Connected Cloud”-ын шийдлүүд нь программ хангамжууд болон хэрэглэгчийн туршлагаудыг нийцүүлсэн шийдлүүдийг боловсруулж, тооцоолол, аюулгүй байдал, контент дамжуулахад зориулагдсан захын (edge platform) болон үүлэн платформын үйлчилгээг өргөнөөр үзүүлж байна. Дэлхийн хамгийн өргөн тархсан сүлжээгээр дамжуулан дэлхийн 4100 гаруй байршилтай бүтэцтэй ба үүгээрээ бусад уламжлалт үүлэн үйлчилгээ тааруу байдаг, хязгаарлагдмал хүрээн дэх хэрэглэгчдэд ч илүү сайн стриминг үйлчилгээ үзүүлж байна.

Үүлэн тооцооллын шилдэг боломжууд нь OTT операторуудад илүү өндөр чанартай, илүү хувь хүнд зориулсан видеог үзэгчдэдээ хүргэх боломжийг олгохын зэрэгцээ үйл ажиллагааны зардал багатай, урьдчилан таамаглаж болохуйц зардал гаргадаг, контентоос мөнгө олох боломжийг сайжруулахад тусалдаг.

Үзэгчдийн хувьд энэ нь хоцролт багатай, хувь хүнд зориулсан, өндөр гүйцэтгэлтэй үйлчилгээ гэсэн үг юм. OTT операторуудын хувьд энэ нь хямд өртөгтэй, урьдчилан таамаглах боломжтой үнээр дэлхийн хэмжээнд үйлчилгээгээ өргөжүүлэх боломжтой гэсэн үг юм.

*Эх сурвалж: AVIA 2024. Жэй Женкинс СТО, Cloud Computing, Akamai Technologies*

## **EVOLVING MEDIA LANDSCAPE: FROM VIEWING HABITS TO NEW TECHNOLOGIES**

### **МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ХУВЬСАН ӨӨРЧЛӨГДӨЖ БУЙ ОРЧИН: ҮЗЭГЧДИЙН ДАДАЛ ЗУРШЛААС ҮҮДЭН ШИНЭ ТЕХНОЛОГИ ҮҮСЭЖ ГАРАХ НЬ**

Сүүлийн 20 жилийн хугацаанд бидний контент үзэх арга замууд маань эрс тэлж, шинэ шатанд хүрсэн. Ази Номхон далайн (APAC) бүс нутгийн улс орнуудын iQiyi, Viu, WeTv, Disney+ Hotstar, Jio Cinema зэрэг олон платформ болон дэлхийн зах зээлд тэргүүлэгч Netflix, Max, Amazon Prime зэрэг компаниуд үзэгчдийн анхаарлыг татахын төлөө өрсөлдөж байгаа энэ үед үзэгчид сонголтоо хийхэд төвөгтэй болсон байна. Ирээдүйд хиймэл дагуулын үйлчилгээ эрхлэгчид болон телевизийн (linear) үйлчилгээ үзүүлэгчдэд ямар өөрчлөлт, нөлөөлөл авчрах бол?

## Өнөө үед бид контентыг хэрхэн үзэж байна вэ?

Өнөөдрийн хувьсан өөрчлөгдөж буй дижитал орчинд орчин үеийн видео хэрэглэгчдийн хувьд контентыг үзэх, хүлээн авахад илүү олон хувилбар, боломжууд бий болж байна. Иймд хэрэглэгчид контентыг зөвхөн сонгох биш, харин өөрсдийн сонирхол, туршлагад үндэслэн хэрэглэхийг илүүд үзэж байна.

Видео стриминг үйлчилгээнүүд тухайн бүс нутаг болон улс оронд илүү хүртээмжтэй, өргөн боломжтой байхаар хөгжүүлэгддэг бөгөөд ихэвчлэн багц үйлчилгээ хэлбэрээр санал болгогддог нь захиалж үзэх хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг.


SVOD зах зээлийн өсөлтөөс үл хамааран Телевизийн олон сувгийг дамжуулах үйлчилгээ нь бүс нутгийн видео зах зээлд ойрын жилүүдэд давамгайлсан байр сууриа хадгалсаар байх бөгөөд 2023 онд нийт орлогын 69 хувийг ( Кабель, IPTV, хиймэл дагуул гм) бүрдүүлж, дэлхийн аль ч бүс нутаг<sup>1</sup> Телевизийн олон сувгийг дамжуулах үйлчилгээ хамгийн өндөр нэвтрэлттэй хэвээр байна.

Газрын сүлжээ, өргөн зурвасын дэд бүтцийн хүртээмж хязгаарлагдмал Индонези зэрэг зах зээлд 2023-2029 оны хооронд зах зээлийн өсөлт жилд дунджаар 4.19%-тай байна гэж тооцоолж байгаа бөгөөд 2029 он гэхэд зах зээлийн хэмжээ 1.8 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна.

---

<sup>1</sup> Pay TV & Online Forecast Report: Asia & Oceania 2023

Стриминг үйлчилгээний өрсөлдөөнөөс үл хамааран телевизийн олон сувгийг дамжуулах үйлчилгээ Ази Номхон Далайн бүсийн ихэнх зах зээлд давамгайлсан платформ хэвээр байх төлөвтэй байна.



Эх сурвалж: Энэхүү судалгааны дүнг AVIA2024 тайлангаас нэмж оруулав.

Энэхүү судалгааны нэг үзүүлэлт болох олон улсад хэрэглэгддэг “Pay television” буюу захиалгат телевизийн үйлчилгээ гэсэн нэр томъёог **телевизийн олон сувгийн дамжуулах үйлчилгээ** гэж ойлгоно.

### Спортын дамжуулалт!

Стриминг дамжуулах үйлчилгээ нь одоогоор спортын шууд нэвтрүүлгийн зах зээлд хараахан давамгайлж чадаагүй байна. Зарим спортын арга хэмжээг стриминг платформ дээр хүлээн авч үзэх боломжтой хэдий ч Олимп, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, Европын хөл бөмбөгийн цом, лиг зэрэг өндөр зэрэглэлийн тэмцээнүүдийн дийлэнх нь телевизийн үндсэн сувгуудаар цацагдсаар байна. Учир нь спортын контент эзэмшигчид хиймэл дагуулын өргөн нэвтрүүлгийн өргөн цар хүрээ, мөн сурталчилгааны орлогоос ашиг хүртсэн хэвээр байгаатай холбоотой юм.

Хиймэл дагуулын сүлжээгээр харилцаа холбоо, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ үзүүлэгч SES компани нь “Хиймэл дагуулаар дамжиж байгаа телевизийн үйлчилгээ нь дэлхийн нэг хэсгээс нөгөө хэсэгт контент дамжуулах хамгийн найдвартай арга хэвээр байгаа” гэж хэлсэн байна. Тус компани нь сүүлийн хэдэн жилийн хугацаанд Азийн болон бусад орнуудад спортын гол арга хэмжээнүүдийг дамжуулахад дэмжлэг үзүүлж ирсэн байна.

Инновац, шинэчлэл үргэлжилсээр байна.



Стриминг дамжуулалтын үйлчилгээнүүд боломжит үзэгчдийг татах шинэ арга замыг эрэлхийлэн, шинэчлэлт хийж, өөрчлөлт хийх үйл явцад орж байна. Стрийминг дамжууллын орчинд, ялангуяа АНУ-д гарсан анхаарал татахуйц хөгжлүүдийн нэг бол **Зар сурталчилгаанд суурилсан үнэгүй стриминг Телевиз** (Free Ad-Supported Streaming Television (мөн FAST гэгддэг) үүсэж, энэ чиг хандлага нь бий болж аажмаар Ази, номхон далайн бүсийн орнуудад аажмаар нэвтэрч байна. *(Орчуулагчийн зүгээс нэмэлт тайлбар. Жнь: FAST платформ-д Pluto TV (Paramount студийн эзэмшдэг) Roku Channel, Tubi г.м.орно. Зар сурталчилгаанд суурилсан үнэгүй стриминг телевиз (FAST) нь захиалгын төлбөр биш, харин зар сурталчилгаагаар санхүүждэг, шууд болон хүссэн контентыг үнэгүй санал болгодог стриминг үйлчилгээний төрөл юм. FAST телевизийн үйлчилгээ нь уламжлалт телевизийн үйлчилгээтэй адил төлөвлөгдсөн хөтөлбөртэй бөгөөд кабель, сансрын хиймэл дагуулын сүлжээгээр бус интернэтээр дамжин хүрдэг онцлогтой.)*

FAST Телевизийн үйлчилгээ нь бусад стриминг платформуудтай адилхан ажилладаг боловч таны гар утас эсвэл ухаалаг телевиз дээр уламжлалт телевизийн давуу талуудыг дуурайсан байдлаар "суваг" үүсгэж тохируулах боломжтой. Энэ чиг хандлага нь уламжлалт телевизийн загвар нь үзэгчдэд сонирхолтой сонголт хэвээр байгааг харуулж байна.

Уламжлалт өргөн нэвтрүүлгийн салбарт шинэ технологийг зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох хэрэгсэл болгон ашиглах чиг хандлага гарч ирж байна.

Жишээлбэл, хэрэглэгчийн зөвшөөрлөөр, үзэгчийн хандлага, үздэг нэвтрүүлэг, үзсэн цаг, сонирхож үздэг хөтөлбөрийг нь хянах боломжтой шинэлэг программ хангамжийн шийдлүүд боловсруулагдаж байна.

Энэ нь урьд өмнө боломжгүй байсан, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдэд үзэгчдээ илүү сайн ойлгож, тэднийг татах шинэ боломжуудыг бий болгож байна.

Цаашилбал, эдгээр хөгжил дэвшлүүд нь тодорхой үзэгчдэд чиглэсэн зар сурталчилгааг хүргэх боломжийг олгож байна. Энэ нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдэд уламжлалт телевизийн сувгуудын контентыг хүргэх найдвартай байдал, зардлын үр ашгийг дээшлүүлэхийн зэрэгцээ зорилтот зар сурталчилгааны ашиг тусыг ашиглах боломжийг олгодог.

Контент дамжуулах хоёр дамжууллын аргыг хослуулсан өөр нэг хөгжиж буй технологи бол DVB Native IP (DVB-NIP) стандарт юм. Энэ нь OTT болон өргөн нэвтрүүлгийн технологийг үр ашигтай, орчин үеийн медиа түгээлтийн шийдэл болгон нэгтгэх боломжийг олгодог. DVB Native IP (DVB-NIP) стандарт *(Орчуулагчийн зүгээс нэмэлт тайлбар: DVB технологийн нэг хэсэг бөгөөд контент дамжуулахдаа IP суваг дамжуулах технологийг ашигладаг, DVB-NIP (Native IP Broadcasting) нь IP протоколд суурилсан, MPEG-2 дамжууллын урсгалын давхаргыг ашиглахгүйгээр дамжуулалтыг хийдэг стандарт юм. )* DVB-NIP нь IP суваг дамжуулах технологийг ашигладаг,

ингэснээр хэрэглэгчид уламжлалт телевизийн үйлчилгээний оронд IP сувгаар контент хүлээн авах боломжтой болдог.

DVB-NIP стандартыг ашиглан видео сигналыг IP форматад натив (цэвэр) байдлаар дамжуулж, хиймэл дагуулаар дамжуулан түгээх төв цэгт хүргэж, цаашид үүрэн холбооны сүлжээгээр дахин түгээх боломжтой болгодог. Энэхүү дэвшил нь алслагдсан бүс нутагт шууд дамжуулалтын үйлчилгээг хүргэхэд томоохон ахиц дэвшил болж байгаа төдийгүй газрын сүлжээний ачааллыг багасгах, видео контент болон шууд дамжуулалтыг өндөр үр дүнтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

### Ирээдүй ямар байх вэ?

Мэдээллийн хэрэгслийн (Медиа) хэрэглээний дадал зуршил олон хүний хувьд хувьсан өөрчлөгдөж байгаа ч хамгийн алслагдсан бүс нутагт хүртэл хүртээмжтэй, найдвартай, тасралтгүй, өндөр чанартай контентыг хүргэх хэрэгцээ үргэлж байх болно. 2025 он гэхэд Ази Номхон далайн бүсийн улс орнуудад интернэт хэрэглэгчдийн 82 хувь нь буюу 2.2 тэрбум хэрэглэгч дижитал видео ашиглана гэж таамаглаж байна<sup>2</sup>. Ази Номхон Далайн орны бүс нутгуудад дамжуулж буй контентуудын ихээхэн хувийг SES гэх мэт хиймэл дагуулын операторуудаар дамжуулна гэж үзэж байгаа бөгөөд энэ нь эдгээр операторуудыг хувьсан өөрчлөгдөж буй медиа орчинд чухал байр суурь эзлэхэд хүргэж, хүмүүсийн контентыг хэрхэн хүлээн авч байгаа арга шийдлүүдэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Эх сурвалж. *The Asia Video Industry Report 2024. Технологи бүлэг. Ивонне Берталом, Бүтээгдэхүүн, маркетингийн захирал, SES компани.*

---

<sup>2</sup> 2 billion people in Asia Pacific will be digital video viewers by 2022.